



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/42

Өлгий

Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай
зөвшөөрөл олгох, хүсэлтийг дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.3, 19.5, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 5.5, 8.1 дүгээр зүйлийн 13 дугаар жагсаалтын 13.8, 13.9, 13.10, 13.11, 13.12, 13.14, 13.15, 13.19, 13.20 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн комиссын 2024 оны 05 дугаар сарын 27-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, эрх шинээр олгох, хүчингүй болгох, зөвшөөрөл нь дэмжигдсэн байгууллагуудын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, зөвшөөрлийн тухай хууль, сумдын эрүүл мэндийн төв, клиник, эмийн санд тавигдах стандарт шаардлагуудыг ханган ажиллахыг тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллагуудад даалгасугай.

3. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн эмийн сан, клиникүүдийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг тусгай зөвшөөрөл олгох комиссын ажлын албад үүрэг болгосугай.

ДАРГА



Н.САКЕН

Эрүүл мэндийн газрын даргын
 2024 оны 05 сарын 28 өдрийн А/42 тоот
 тушаалын 1.7.8.4.1.1 хавсралт

ХТЭБ0018

**НЭГ. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН
 ЭРХ ШИНЭЭР ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Хүчинтэй хугацаа
1	"Монос фарм маркет 2"	Эмийн сан	3 жилээр	2027.05.27

**ХОЁР:МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ НЬ
 СУНГАГДСАН БАЙГУУЛЛАГУУД:**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Хүчинтэй хугацаа
1	"Бота фарм"	Эмийн сан	5 жилээр	2029.05.27
2	"Сая фарм"	Эмийн сан	5 жилээр	2029.05.27
3	"Алтай СЭМТ"	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ	5 жилээр	2029.06.08
4	"Бугат СЭМТ"	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ	5 жилээр	2029.06.08
5	"Буюнт СЭМТ"	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ	5 жилээр	2029.06.08

**ГУРАВ:МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ НЬ
ДЭМЖИГДСЭН БАЙГУУЛЛАГА**

1.Өлгий сумд “Гялс” ХХК-ийн “Гялс” баруун бүсийн салбар лаборатори
ажиллуулах төсөл

2.Толбо сумд “Сайрын ирвэс” ХХК-ийн “Биофарм” эмийн сан нээх төсөл

ДӨРӨВ: ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЭРХИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

1.Өлгий сум “Биофарм” эмийн сан

2.Өлгий сум “Асыл мед” мэдрэлийн өвчний оношилгоо, эмчилгээний клиник

3.Толбо сум “Гүлфарм” эмийн сан

ТАВ:НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ:

1.“Ахихат айнасы” ХХК-ийн “Астма” хүүхдийн өвчний тусламж үйлчилгээний үүдэн
эмнэлэг “Яс сийрэгжилтийн оношлогоо үйлчилгээг” хасах.